



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 494

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох  
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гаалийн ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын албан ажлын хэрэгцээнд зориулан 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 1 ширхэг бага оврын автобус олж авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын дарга Ш.Чухалбуян нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн  
48 дугаар тогтоолын хавсралт



Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын олж авах  
автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар

Д/д	Хөрөнгийн нэр	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо ширхэг	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Бага оврын автобус, хөдөлгүүрийн багтаамж 3456 cc хүртэл, суудлын тоо 16	119,000,000.00	1	119,000,000.00
	<b>Нийт дүн</b>		<b>1</b>	119,000,000.00 (нэг зуун арван есөн сая)